



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн  
аудит

Аудитын код: БНА-2019/1/СТА-ТШЗ

Баянхонгор  
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576      Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024      Цахим хаяг: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)

Аудитор:              Ж.Өсөхбаяр

Утас: 99890393      Цахим хаяг: [usukhbayar\\_j@yahoo.com](mailto:usukhbayar_j@yahoo.com)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил .....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

1 Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ПРОКУРОРЫН ГАЗРЫН  
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
Б.ТӨРБОЛД ТАНАА

2019.02.15 № 2/15

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын

E:\Usukhuu\СТА-2019\3.Прокурорын газар\4.Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2518495

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Тамгын хэлтсийн дарга Б.Төрболдод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 21-нээс 2019 оны 01 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 2/20 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь “Монгол Улсын Үндсэн хуульд заасан прокурорын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, баталгаа, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, эрх хэмжээ, бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтооход оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Прокурор ажилтнуудын ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах,
- Шинээр батлагдсан хууль, заавар, журмуудын хэрэгжилтийг нэг мөр хангуулах
- Прокурор, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх.
- Прокурор, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах

Баянхонгор аймгийн Прокурорын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Прокурорын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор аймгийн Прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд

үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 384447.9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 7688.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гараагүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### **2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Байхгүй

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Байхгүй

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 378938.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 378519.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь 2018 онд 37519.6 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 418.3 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор аймгийн Прокурорын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгдээгүй болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/Төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,424,110.00</b>	<b>11,079,258.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3,000,000.00	3,000,000.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	3,000,000.00	3,000,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	3,000,000.00	3,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	3,000,000.00	3,000,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	102,410.00	166,008.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	102,410.00	166,008.00
3351	Байгууллагаас авах авлага	102,410.00	166,008.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	6,321,700.00	7,913,250.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	195,000.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	195,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	6,321,700.00	7,718,250.00
35410	Бичиг хэргийн материал	544,200.00	1,103,950.00
35420	Аж ахуйн материал	5,224,200.00	5,421,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	413,300.00	563,300.00
35470	Бусад хангамжийн материал	140,000.00	629,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>319,411,248.07</b>	<b>528,779,758.58</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	319,411,248.07	528,779,758.58
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	319,411,247.95	528,779,758.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	344,500,000.00	511,201,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,666,666.76	-200,000.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,900,000.00	67,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,900,000.00	-67,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,426,366.75	26,478,863.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,763,357.36	-20,534,157.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,738,940.00	22,017,117.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,290,534.68	-10,183,544.68
39217	Ном	466,500.00	00.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.12	00.12
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-399,999.88	-399,999.88
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>328,835,358.07</b>	<b>539,859,016.58</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,000,000.00	3,000,000.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	3,000,000.00	3,000,000.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	3,000,000.00	3,000,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>325,835,358.07</b>	<b>536,859,016.58</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	325,835,358.07	536,859,016.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	388,903,922.12	388,903,922.12
51101	Өмч: - төрийн	388,903,922.12	388,903,922.12
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-63,068,564.05	-64,500,185.62
51210	Өмнөх үеийн үр дүн	-63,068,564.05	-63,547,364.05
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-952,821.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	212,455,280.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>328,835,358.07</b>	<b>539,859,016.58</b>

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>348,355,111.00</b>	<b>383,495,147.79</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,410.00</b>	<b>4,557,147.79</b>
120	Нийтлэг татварын бус орлого	14,410.00	4,557,147.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,410.00	4,557,147.79
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,410.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	4,557,147.79
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>348,340,701.00</b>	<b>378,938,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>347,305,800.00</b>	<b>378,938,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,305,800.00	378,938,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>600,000.00</b>	<b>00.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>434,901.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	434,901.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>369,916,895.72</b>	<b>383,021,469.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>369,916,895.72</b>	<b>383,021,469.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>366,425,494.72</b>	<b>381,803,070.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлд болон нэмэгдэл урамшил</b>	<b>264,010,746.00</b>	<b>288,015,856.00</b>
210101	Үндсэн цалин	248,541,746.00	253,997,277.00
210102	Нэмэгдэл	11,106,000.00	32,401,579.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,109,000.00	1,617,000.00
210105	Гэрээт ажлын хөлд	2,254,000.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,885,256.00</b>	<b>34,727,783.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,368,662.00	21,938,415.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,099,277.00	4,358,239.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,624,094.00	2,881,525.00
210204	Ажилгүйдлийн даатгал	524,824.00	966,147.00
210205	Эрүүд мэндийн даатгал	5,268,399.00	4,583,457.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,658,693.00</b>	<b>25,498,332.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,246,969.00	2,935,926.00
210302	Түлш, халаалт	16,686,824.00	20,089,025.00
210303	Цэвэр, бохир ус	724,900.00	2,473,381.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,506,598.00</b>	<b>20,355,916.00</b>
210401	Бичиг хэрэг	6,020,240.00	9,318,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,829,900.00	6,618,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,610,208.00	1,990,516.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,500.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	960,750.00	2,248,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40,100.00</b>	<b>2,866,500.00</b>
210604	Урсгал засвар	40,100.00	2,866,500.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>1,293,500.00</b>	<b>2,331,000.00</b>
210702	Дотоод албан томилголт	1,293,500.00	2,331,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>365,132.00</b>	<b>1,871,650.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,832.00	1,521,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,300.00	151,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	133,000.00	176,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,665,469.72</b>	<b>6,136,033.36</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,835,750.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	334,800.00	327,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,494,919.72	5,808,333.36
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,491,401.00</b>	<b>1,218,399.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,491,401.00</b>	<b>800,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	434,901.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,056,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>418,399.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	418,399.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-21,561,784.72</b>	<b>473,678.43</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>1,426,500.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,426,500.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-1,426,500.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-21,561,784.72</b>	<b>-952,821.57</b>

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>351,340,701.00</b>	<b>388,448,734.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,000,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,000,000.00	00.00
120009	Бусад орлого	3,000,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>348,340,701.00</b>	<b>388,448,734.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	347,305,800.00	378,938,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,305,800.00	378,938,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	600,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	434,901.00	9,510,734.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	434,901.00	9,510,734.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>335,123,084.00</b>	<b>388,448,734.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>335,123,084.00</b>	<b>388,448,734.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>331,631,683.00</b>	<b>377,719,601.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	267,103,069.00	287,853,853.00
210101	Үндсэн цалин	214,773,295.00	153,824,900.00
210102	Нэмэгдэл	37,982,774.00	119,582,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,185,000.00	9,616,953.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,162,000.00	4,830,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,885,255.00	34,724,600.00
210201	Тэтгэврийн даатгал	27,913,429.00	29,603,613.00
210202	Тэтгэмжийн даатгал	194,365.00	1,276,018.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	242,957.00	1,201,553.00
210204	Ажилгүйдлийн даатгал	48,591.00	240,311.00
210205	Эрүүл мэндийн даатгал	485,913.00	2,403,105.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,802,500.00	25,498,332.00
210301	Гэрэл, цахилгаан	2,246,969.00	2,852,976.00
210302	Түлш, халаалт	15,830,631.00	21,448,762.00
210303	Цэвэр, бохир ус	724,900.00	1,196,594.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,193,827.00	19,391,966.00
210401	Бичиг хэрэг	4,333,590.00	7,460,850.00
210402	Тээвэр, шатахуун	3,869,900.00	6,389,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,178,337.00	2,219,916.00
210404	Ном, хэвлэл	00.00	23,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,500.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	726,500.00	3,119,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	50,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	3,500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	3,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,293,500.00	2,150,000.00
210702	Дотоод албан томилолт	1,293,500.00	2,150,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	385,132.00	4,170,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,832.00	3,799,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,300.00	151,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	133,000.00	198,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,418,400.00	430,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,018,400.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	430,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,491,401.00</b>	<b>10,729,133.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,491,401.00	10,310,734.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	434,901.00	9,510,734.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,056,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	418,399.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	418,399.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>16,217,617.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	16,217,617.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	3,000,000.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	16,217,617.00	3,000,000.00

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**3.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	388,903,922.12	00.00	-67,866,842.57	321,037,079.55
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,333,500.00	2,333,500.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>388,903,922.12</b>	<b>00.00</b>	<b>-65,533,342.57</b>	323,370,579.55
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-3,201,965.89	-3,201,965.89
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>388,903,922.12</b>	<b>00.00</b>	<b>-63,068,564.05</b>	325,835,358.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-478,800.00	-478,800.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>388,903,922.12</b>	<b>00.00</b>	<b>-63,547,364.05</b>	325,356,558.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	212,455,280.08	00.00	212,455,280.08
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-952,821.57	-952,821.57
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>388,903,922.12</b>	<b>212,455,280.08</b>	<b>-64,500,185.62</b>	536,859,016.58

**3.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайланг оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	366,795,200.00	366,757,700.00	378,938,000.00	378,519,601.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	366,795,200.00	366,757,700.00	378,938,000.00	378,519,601.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	361,890,700.00	361,853,200.00	378,138,000.00	377,719,601.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	289,456,600.00	289,456,600.00	287,938,100.00	287,853,853.00
210101	Үндсэн цалин	227,489,000.00	227,489,000.00	153,824,900.00	153,824,900.00
210102	Нэмэгдэл	44,418,000.00	44,418,000.00	119,582,000.00	119,582,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,649,600.00	8,649,600.00	9,701,200.00	9,616,953.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,900,000.00	8,900,000.00	4,830,000.00	4,830,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,911,500.00	31,903,360.00	34,724,600.00	34,724,600.00
210201	Тэтгэврийн даатгал	19,251,700.00	30,931,534.00	23,375,400.00	29,603,613.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,164,900.00	194,365.00	2,837,300.00	1,276,018.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,461,900.00	242,957.00	2,269,800.00	1,201,553.00
210204	Ажилгүйдлийн даатгал	703,300.00	48,591.00	567,500.00	240,311.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,329,700.00	485,913.00	5,674,600.00	2,403,105.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,481,500.00	22,453,282.00	25,808,000.00	25,498,332.00
210301	Гэрэл, цахилгаан	1,458,000.00	2,448,573.00	1,458,000.00	2,852,976.00
210302	Түлш, халаалт	18,611,000.00	19,230,849.00	21,900,000.00	21,448,762.00
210303	Цэвэр, бохир ус	2,412,500.00	773,860.00	2,450,000.00	1,196,594.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,930,000.00	12,928,926.00	19,392,000.00	19,391,966.00
210401	Бичиг хэрэг	5,755,000.00	5,186,090.00	10,100,000.00	7,460,850.00
210402	Тээвэр, шатахуун	4,800,000.00	3,884,900.00	5,100,000.00	6,389,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	2,916,336.00	2,380,000.00	2,219,916.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	45,000.00	23,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	75,000.00	85,500.00	95,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	856,100.00	1,672,000.00	3,119,100.00
2105	<b>Нормативт зардал</b>	50,000.00	50,000.00	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	50,000.00	00.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00	3,500,000.00	3,500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	3,500,000.00	3,500,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,357,500.00	1,357,500.00	2,150,000.00	2,150,000.00
210702	Дотоод албан томилолт	1,357,500.00	1,357,500.00	2,150,000.00	2,150,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	385,200.00	385,132.00	4,195,300.00	4,170,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,900.00	96,832.00	3,823,500.00	3,799,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,300.00	155,300.00	151,800.00	151,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	133,000.00	133,000.00	198,000.00	198,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	281,840.00	281,840.00	430,000.00	430,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,418,400.00	2,418,400.00	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	400,000.00	430,000.00	430,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	490,450.00	490,450.00	800,000.00	800,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,904,500.00	4,904,500.00	800,000.00	800,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,056,500.00	3,056,500.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,848,000.00	1,848,000.00	800,000.00	800,000.00

**Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	366,795,200.00	366,757,700.00	378,938,000.00	378,519,601.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	366,795,200.00	366,757,700.00	378,938,000.00	378,519,601.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	366,795,200.00	366,757,700.00	378,938,000.00	378,519,601.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	3,000,000.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	3,000,000.00	00.00	3,000,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	16.00	17.00	16.00	17.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	07.00	07.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	06.00	06.00
620004	Гэрээт ажилтан	00.00	01.00	00.00	01.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>16.00</b>	<b>17.00</b>	<b>16.00</b>	<b>17.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	01.00	01.00	01.00	01.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	07.00	07.00	07.00	07.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	02.00	02.00	02.00	02.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	06.00	06.00
650010	Гэрээт ажилтан	00.00	01.00	00.00	01.00